



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 181/ШШ2019/00489

Улаанбаатар хот

Хариуцагчийн зөвшөөрлийг баталж,
хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч
Б.Баатар би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж,
“Ньюмаинд групп” ХХК-ийн байранд байрлах, “Лэндмн ББСБ” ХК /РД:5039754/-ийн
нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Эрхүүгийн гудамж, 11
хороолол, 11 байр, 16 тоот хаягт оршин суух, Байкелди овогт Сесерийн Ерханат
/РД:БЭ78022813/-д холбогдох,

Зээлийн төлбөр 1,200,000 төгрөг, шимтгэл 37,000 төгрөг, нотариатын
үйлчилгээний төлбөр 47,238 төгрөг, нийт 1,284,238 гаргуулах тухай хэргийг хүлээн
авч хянаад,

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дэлгэржаргал
шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Сесерийн Ерханат нь Иргэний хууль, Банк, эрх
бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай
хууль болон өөрийн хүсэлтийн дагуу “Лэндмн ББСБ” ХК-тай 2017 оны 01 сарын 17-
ний өдөр 10960 дугаартай Цахим зээлийн эрх нээх гэрээг байгуулсан билээ.

“Лэндмн ББСБ” ХК зээлдэгч С.Ерханатын Лэндмн аппликейшнээр дамжуулан
гаргасан хүсэлтийн дагуу 2018 оны 06 сарын 26-ний өдөр 950,000 төгрөгийн зээлийг
29,000 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай, 2018 оны 07 сарын 26-ны
өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэй, 2018 оны 06 сарын 28-ний өдөр 250,000
төгрөгийн зээлийг 8,000 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай, 2018 оны
07 сарын 28-ны өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэй, тус тус олгож нийт 1,200,000
төгрөг С.Ерханатын Голомт банкны 1309169825 тоот дансанд шилжүүлсэн.

Зээлдэгч С.Ерханат нийт 2 үндсэн зээлийн дүн болох ,1200,000 төгрөг,
шимтгэл болох 37,000 төгрөгийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа юм.

Зээлдэгч нь зээлийн гэрээний 4.2.2 заалтыг зөрчин, зээлийг хугацаанд нь
эргэн төлөх үүргээ биелүүлээгүй байна.

С.Ерханатыг гэрээний үүргээ биелүүлэх, зээлээ төлөхийг удаа дараа
шаардсан боловч эргэн төлөлтийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа тул хариуцагч
С.Ерханатаас үндсэн зээлийн төлбөр 1,200,000 төгрөг, зээлийн шимтгэл 37,000
төгрөгийг гаргуулах хүсэлтэй байна.

Иймд хариуцагч С.Ерханатаас үндсэн зээлийн төлбөр 1,200,000 төгрөг,
шимтгэл 37,000 төгрөг, нотариатын үйлчилгээний төлбөр 47,238 төгрөг, нийт
1.284.238 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

Хариуцагч С.Ерханат шүүхэд гаргасан хариу тайлбартаа: Миний бие С.Ерханат нь “Лэндмн ББСБ” ХК-ийн нэхэмжилсэн 1,284,238 төгрөгийг хүлээн зөвшөөрч байна. Маргаан байхгүй, төлж барагдуулах болно гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК-ийн нэхэмжлэлийн шаардлага 1,284,238 төгрөгийг хариуцагч С.Ерханат хүлээн зөвшөөрч, төлж барагдуулахаар тайлбар гаргасан нь хариуцагчийн шүүхэд бичгээр ирүүлсэн хариу тайлбараар тогтоогдсон, хариуцагчийн зөвшөөрөл нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байх тул хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзлээ.

Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тул улсын тэмдэгтийн хураамжийг хуульд заасны дагуу тал хувиар бууруулан тогтоож хуваарилав.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1., 74.2., 75 дугаар зүйлд заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Лэндмн ББСБ” ХК-ийн нэхэмжлэлтэй, С.Ерханатад холбогдох, 1,284,238 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт нэхэмжлэлийн шаардлага 1,284,238 төгрөгийг хариуцагч С.Ерханат төлөхөөр хүлээн зөвшөөрснийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5.-д зааснаар нэхэмжлэгчийн Улаанбаатар хотын банк Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн 2611192214 дугаарын дансанд улсын тэмдэгтийн хураамжид 2019 оны 01 сарын 25-ны өдөр төлсөн 34,238 төгрөг, 2019 оны 01 сарын 28-ны өдөр төлсөн 1,133.71 төгрөг, нийт 35,371.71 төгрөгийн 17,685.8 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд хэвээр үлдээж, 17,685.8 төгрөгийг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, орон нутгийн төсвийн орлогын 200600910 данснаас, тэмдэгтийн хураамжид хариуцагч С.Ерханатаас 17,685.8 төгрөгийг тус тус гаргуулж нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК-д олгосугай.

3.Шүүгчийн захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлэхгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэхийг дурдсугай.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4-д зааснаар зохигч давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Б.БААТАР